



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

БИЧИЛ УУРХАЙГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ОРУУЛАХ, АЛБАЖУУЛАХ ГАРЫН АВЛАГА





**УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг**

БИЧИЛ УУРХАЙГ ЗОХИОН БАЙГУУЛААЛТАД ОРУУЛАХ, АЛБАЖУУЛАХ ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2017 он

ΔΑΑ 622
ННА 33
Б-505

Бичил уурхайг зохион байгуулалтад оруулах, албажуулах гарын авлага

Боловсруулсан: Т.Энхцэцэг

Хянан тохиолдуулсан: Б.Хулан

©Бүх эрхийг Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл эзэмшинэ.

ISBN 978-99978-4-134-6

АГУУЛГА

1. Оршил	5
2. Бичил уурхайг зохион байгуулалтад оруулах, албажуулах	5
3. Бичил уурхай эрхлэхэд тавигдах шаардлага	6
3.1 Бичил уурхай эрхлэх иргэдэд тавигдах шаардлага	6
4. Бичил уурхайн зохион байгуулалтад орох	8
4.1 Нөхөрлөл	9
4.2 Хоршоо	10
4.3 Бүртгэгдээгүй нөхөрлөл	12
5. Бичил уурхайн үйл ажиллагааг албажуулах	14
5.1 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох өргөдөл гаргах	14
5.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газрын асуудлыг шийдвэрлэх нь	15
5.3 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах	17
6. Бичил уурхайчдад тавигдах шаардлага	19
6.1 Бичил уурхай эрхлэгч ямар татвар, төлбөр төлөх вэ?	19
6.2 ХАБЭА-н шаардлагуудыг хангаж ажиллах	20
6.3 Байгаль орчны шаардлагуудыг хангаж ажиллах	24
6.4 Олборлосон ашигт малтмалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу борлуулах	25
7. Бичил уурхайн үйл ажиллагаанд хориглох зүйлс	27

Бичил уурхайг хуулийн хүрээнд хэрхэн зохион байгуулалтад оруулах, албажуулах талаарх мэдээллийг бичил уурхай эрхлэгчид, орон нутгийн удирдлагууд болон бусад оролцогч талуудад багцалж хүргэх зорилгоор энэхүү гарын авлагыг бэлтгэв.



1

ОРШИЛ

2010 онд Ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” батлагдсан.

2014 оны 1 дүгээр сард УИХ-ын 18 дугаар тогтоолоор 2014-2025 он хүртэл Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогыг баталсан. Энэхүү бодлогын бичиг баримтад зааснаар төрөөс “бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг төрөөс бодлогоор дэмжиж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох” бодлого баримталж байгаа юм.

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” хэрэгжсэн өнгөрсөн 6 жилийн хугацаанд журмыг шинэчлэн боловсруулах эрх зүйн болон практик шаардлагууд гарч ирсэн.

Иймд бичил уурхайн холбогдох талуудын санаа, бодлыг тусган “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор баталсан байна.

Энэхүү журмаас гадуур ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулбал хууль бүс үйл ажиллагаа болно. Иймд бичил уурхайг хуулийн хүрээнд хэрхэн зохион байгуулалтад оруулах, албажуулах талаарх мэдээллийг бичил уурхай эрхлэх хүсэлтэй иргэд, бичил уурхайчид, орон нутгийн удирдлагууд болон бусад оролцогч талуудад багцалж хүргэх зорилгоор энэхүү гарын авлагыг бэлтгэв.

2

БИЧИЛ УУРХАЙГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ОРУУЛАХ, АЛБАЖУУЛАХ

Бичил уурхайг зохион байгуулалтад оруулах, албажуулах үйл явц дараах үе шаттай байна.

1. Бичил уурхай эрхлэхэд тавигдах шаардлагуудыг хангах
2. Бичил уурхайн зохион байгуулалтад орох
3. Бичил уурхайн үйл ажиллагааг албажуулах
4. Бичил уурхайд тавигдах шаардлагыг хангах

3

БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Бичил уурхайн тодорхойлолт

Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т “бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг ойлгоно гэж тодорхойлжээ.

3.1 Бичил уурхай эрхлэх иргэдэд тавигдах шаардлага

- 1) Монгол Улсын иргэн байх,
- 2) 18 нас хүрсэн байх,
- 3) Тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн байх,
- 4) Нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлд гишүүнээр элссэн байх.

1) Монгол Улсын иргэн байх.



Бичил уурхайн аливаа үйл ажиллагааг зөвхөн Монгол Улсын иргэн эрхлэх бөгөөд гадаадын иргэн, харьяалалгүй хүн эрхлэхийг хориглоно.

2) 18 нас хүрсэн байх:

Монгол Улсын Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/36 тушаалаар Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг шинэчлэн баталсан. Энэ жагсаалтад зааснаар уул уурхай, олборлолтын аливаа үйл ажиллагааг насанд хүрээгүй хүний амь нас, эрүүл мэнд, ёс суртахуун, аюулгүй байдалд нийтлэг аюултай ажлын байр, ажил мэргэжил гэж тодорхойлсон байна.



3) Тухайн аймаг, нийслэлд оршин суугчаар бүртгүүлсэн байх:

Монгол Улсын Иргэний бүртгэлийн хуулийн 25.1-д зааснаар “Иргэн байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээсээ нөгөөд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүр мөсөн шилжин суурьших, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухыг түр шилжин суурьших гэнэ.

Иргэн аливаа засаг захиргааны нэгжид 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухдаа 10 хоногийн дотор холбогдох сум, дүүргийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж, ажилтанд оршин суугаа газрынхаа хаягийн бүртгэлийг иргэний үнэмлэхэд

тэмдэглүүлнэ. Шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгүүлэхдээ өмнө оршин сууж байсан нутаг дэвсгэрийн сум, дүүрэг, хорооны хүн амын бүртгэлээс хасуулсан тухай тодорхойлолтыг иргэний үнэмлэхийн хамт авчирна.

4) Нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлд гишүүнээр элссэн байх:

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хүсэлтэй иргэд нь Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан нөхөрлөл, хоршоонд гишүүнээр элсэнэ.

4

БИЧИЛ УУРХАЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ОРОХ

Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.23-т зааснаар бичил уурхай эрхлэх иргэд

- Бүртгэгдээгүй нөхөрлөл,
- Нөхөрлөл,
- Хоршооны аль нэг хэлбэрийг сонгон зохион байгуулалтанд орно.

Бичил уурхай эрхлэх иргэд өөрсдөө санал санаачлага гаргаж, зохион байгуулалтад орох нь орон нутгийн удирдлагад бичил уурхай




эрхлэх тухай өргөдөл гаргах, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газрын асуудлыг шийдвэрлүүлэх ажлын эхний алхам болно.

Ийнхүү зохион байгуулалтанд ороход сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын холбогдох мэргэжлийн хүмүүсээс эрх зүйн туслалцаа, зөвлөлгөө авах эрхтэй.

4.1 Нөхөрлөл

Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөлийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, түүний бүтэц, зохион байгуулалт, өөрчлөлт, татан буулгахтай холбоотой харилцааг “Нөхөрлөлийн тухай” хуулиар зохицуулна.

Нөхөрлөл байгуулахын тулд бичил уурхай эрхлэгчид нөхөрлөлийн гишүүнээр элсэж, үүсгэн байгуулах гэрээ байгуулж, нөхөрлөлийн дүрмийг батална.



Нөхөрлөл дор дурдсан хэлбэрээр зохион байгуулагдаж болно:

- 1/ бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай;
- 2/ зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай.
- 3/хязгаарлагдмал хариуцлагатай.

1/ Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл: Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.

2/ Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл: Нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд

оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь гагцхүү нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.

3/ **Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл:** Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хоёр ба түүнээс дээш иргэн хамтран байгуулах бөгөөд нөхөрлөлийн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээгээр, нөхөх хариуцлагыг буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн хөрөнгийн хэмжээгээр бүрэн хариуцна.

Нөхөрлөл оноосон нэртэй байна. Нөхөрлөлийг оршин байгаа газрынх нь нутаг дэвсгэрийн бүртгэх байгууллага, тэдгээрийн өргөдлийг үндэслэн улсын бүртгэлд бүртгэнэ. Нөхөрлөлийг бүртгүүлэхдээ Бүртгэлийн байгууллагад нөхөрлөлийг бүртгүүлэх өргөдөл гаргахдаа үүсгэн байгуулах гэрээ, дүрэм, гишүүдийн оруулсан хөрөнгийн талаарх баталгаа зэрэг бичиг баримтыг хавсаргана. Бүртгэх байгууллага өргөдлийг хүлээн авч хянаад энэ хуульд заасан шаардлага хангасан гэж үзвэл нөхөрлөлийг ажлын 7 хоногийн дотор улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоно.


4.2 Хоршоо

Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, үйл ажиллагаа нь



дуусгавар болох, түүний зохион байгуулалт, хоршооны гишүүнчлэл, хоршооны үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл зэрэгтэй холбогдсон харилцааг Хоршооны тухай хуулиар зохицуулна.

Хоршооны тухай хуулийн 3.1-д зааснаар “Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан хамтын, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.”



Хоршоо нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаанаас бусад хэд хэдэн үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхэлж болно.

Анхан шатны Хоршоог 9-өөс доошгүй иргэн, дундын хоршоог хоёроос доошгүй хуулийн этгээд байгуулж болно.

Хоршоо нь оноосон нэртэй байна. Хоршооны оноосон нэрний ард “Хоршоо” гэсэн ялгах тэмдгийг хэрэглэнэ.

Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг нь хоршооны дүрэм байна. Хоршооны дүрмийг бүх гишүүдийн хурлаар батална. Хоршооны дүрэм баталснаас хойш 30 хоногийн дотор харьяалах нутаг дэвсгэрийн бүртгэх байгууллагад хоршоог бүртгүүлэх өргөдөл гаргана.

Бүртгэх байгууллага нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл 14 хоногийн дотор хоршоог улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгоно.

4.3 Бүртгэгдээгүй нөхөрлөл

Иргэний хуулийн 481 дүгээр зүйлийн 481.1 дэх хэсэгт “Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлно” гэж заасан байдаг.

Бичил уурхай эрхлэх иргэд бүртгэгдээгүй нөхөрлөл байгуулахын тулд хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулж, нөхөрлөлийн дүрмийг батална. Нөхөрлөл нь оноосон нэртэй байх бөгөөд гишүүдийн тоо 9-өөс цөөнгүй байна.

Бүртгэгдээгүй нөхөрлөлийн гишүүд нь нөхөрлөлийн дундын хөрөнгөтэй байх бөгөөд дундын хөрөнгө шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд хариуцлагыг ижил хэмжээгээр хувийн хөрөнгөөр нөхөх хариуцлага хүлээнэ.

Нөхөрлөл, хоршоо, бүртгэгдээгүй нөхөрлөлийн ялгаа

Ялгаа	Хоршоо	Бүртгэгдээгүй нөхөрлөл	Нөхөрлөл
Хуулийн этгээд эсэх	Хуулийн этгээд, Улсын бүртгэлд бүртгүүлж тамга тэмдэг авна.	Хуулийн этгээд биш. Улсын бүртгэлд бүртгүүлэхгүй. Тамга тэмдэггүй.	Хуулийн этгээд, Улсын бүртгэлд бүртгүүлж тамга тэмдэг авна.
Ямар зорилготой вэ?	Гишүүдийнхээ орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэх	Ашиг олох болон бусад тодорхой зорилгыг хэрэгжүүлэх	Ашиг олох, ашгаа нэмэгдүүлэх
Ашгийн төлөө юу?	Ашгийн төлөө бус	Ашгийн төлөө	Ашгийн төлөө
Хэрхэн үүсгэн байгуулагддаг вэ?	9-өөс доошгүй иргэд хамтран хоршоог үүсгэн байгуулдаг	9-өөс доошгүй иргэд зохион байгуулдаг.	Нөхөрлөлийн гишүүд хамтран үүсгэн байгуулдаг.
Хэн удирддаг вэ?	Зөвхөн гишүүдээс сонгогдсон Тэргүүлэгчид хоршоог удирддаг	Зөвхөн гишүүдээс сонгогдсон ахлагч.	Нөхөрлөлийн гишүүд хөрөнгө оруулсан хөрөнгөний хэмжээнээс хамаарч

Ялгаа	Хоршоо	Бүртгэгдээгүй нөхөрлөл	Нөхөрлөл
Хэн өмчилдөг вэ?	Гишүүдийн дундын өмчлөлтэй	Гишүүдийн дундын өмчлөлтэй.	Нөхөрлөлийн гишүүд өмчилдөг
Үйл ажиллагаанд хэн оролцдог вэ?	Гишүүд хөрөнгөө нэгтгэн өөрсдийн мэдлэг, ур чадвараа дайчлан оролцдог (бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хамтарч борлуулах гэх мэт аль нэг хэлбэрээр заавал оролцдог)	Талууд үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлнэ.	Бүрэн хариуцлагатай гишүүд нь заавал, бүрэн бус хариуцлагатай гишүүд заавал оролцохгүй байж болно.
Хариуцлагаа хэрхэн хуваалцдаг вэ?	Оруулсан хөрөнгөөр, мөн дүрэмд заасан хэмжээгээр нөхөх хариуцлага хүлээнэ	Хамтын үйл ажиллагааны улмаас гарсан алдагдлыг талууд хамтран хүлээнэ.	Бүрэн хариуцлагатай гишүүд нь оруулсан хөрөнгөнөөс гадна хувийн хөрөнгөөрөө хариуцлага хүлээдэг, бүрэн бус хариуцлагатай гишүүд оруулсан хөрөнгөөрөө хариуцлага хүлээдэг.
Ашгийг хэн хүртдэг вэ?	Гишүүд	Гишүүд	Гишүүд

Та одоо бичил уурхайн зохион байгуулалтын хэлбэрт орлоо. Зохион байгуулалтад орсны дараах үе шат бол албажих явдал юм.

Дараах хэсэгт зохион байгуулалтад орсон бичил уурхайн байгууллага хэрхэн албажих талаар өгүүлнэ.

Бичил уурхай эрхлэх иргэд Иргэний хуулийн 481.1 дүгээр зүйлд заасан бүртгэгдээгүй нөхөрлөл, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл, эсвэл хуулийн 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулалтад орсныг цаашид нийтэд нь Бичил уурхай эрхлэгч этгээд гэнэ.

5

БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ АЛБАЖУУЛАХ

Үйл ажиллагаагаа албажуулахын тулд та дараах зүйлсийг хийх зайлшгүй шаардлагатай болдог.

1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох өргөдөл гаргах
2. Бичил уурхайгаар олборлох газрын асуудлыг шийдвэрлэх
3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах

5.1 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох өргөдөл гаргах

Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох зорилгоор байгуулагдсан бичил уурхай эрхлэгч этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах тухай өргөдлөө сум, дүүргийн Засаг даргад маягтын дагуу бичгээр гаргана.



Өргөдөлд дараах зүйлийг заавал тусгана:

- а) Бүртгэгдээгүй нөхөрлөл, Нөхөрлөл эсвэл Хоршооны нэр, удирдах буюу төлөөлөх эрх бүхий этгээд болон гишүүдийн нэр, хаяг;
- б) талбайн байршил;
- в) олборлох ашигт малтмалын төрөл.

Өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

- a) Үүсгэн байгуулсан гэрээ, дүрмийн хуулбар;
- b) Бичил уурхайчдын үнэмлэхний хуулбар;
- c) Нөхөрлөл буюу хоршооны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- d) Олборлолт явуулах талбайн байршлын зураг;
- e) Бичил уурхайчдын албан татвар төлөгчийн бүртгэлийн дэвтрийн хуулбар;
- f) Бичил уурхайчдын нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
- g) Тухайн талбайг сонгосон үндэслэл, тайлбар.

5.2 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газрын асуудлыг шийдвэрлэх нь

Сум, дүүргийн Засаг дарга бичил уурхай эрхлэгч этгээдийн гаргасан өргөдлийг хүлээн авч шаардлага хангасан тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг даргад уламжилна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдуулж, сум, дүүргээр бүсчилсэн байдлаар төлөвлөгөө боловсруулж, нэгдсэн удирдлагаар хангаж бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авахаар сонгосон газрын талаар дүгнэлт гаргуулах тухай саналыг хүлээн авч дүгнэлт гаргуулах хүсэлтийг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлнэ.

Энэхүү хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргаж явуулна:

1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар бичил уурхай эрхлэгч этгээдээс гаргасан өргөдлийн хуулбар
2. Сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар бичил уурхай эрхлэгч этгээдийн гаргасан өргөдлийг үндэслэн тухайн талбайд дүгнэлт гаргуулах саналыг уламжилсан албан бичиг

Ашигт малтмал, газрын тосны газар аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан хүсэлтийг хүлээн авч сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхацсан эсэх талаар дүгнэлт гаргаж, газрын хэмжээ, хил хязгаарыг тогтооно. Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн



тусгай хэрэгцээнд авах боломжтой эсэх талаарх дүгнэлтийг (Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23) ажлын 10 хоногт багтааж гарган, уг дүгнэлтэд холбогдох мэдээллийг хавсарган Аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд газар дээр нь ажиллана.


Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төрийн захиргааны байгууллагаас “боломжтой” гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг даргаас ирсэн саналыг хүлээн авч тухайн газрыг Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай шийдвэр гаргаж, шийдвэрийг ажлын 5 өдөрт багтаан аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бичил уурхайн зориулалтаар газрыг тусгай хэрэгцээнд авсан талаар гаргасан шийдвэрийг сум, дүүргийн Засаг даргад хүргүүлж, Ашигт малтмалын тухай хуулийн 14.1-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, бүртгүүлнэ.

Бичил уурхай эрхлэгч этгээдийн гаргасан өргөдлийн дагуу бичил уурхайн зориулалтаар олборлолт явуулах газрын асуудал ямар шатанд явж байна, Ашигт малтмал, газрын тосны газраас ямар дүгнэлт гарсан, боломжтой гэсэн дүгнэлт гарсан талбайд өргөдөл

гаргасан этгээдтэй гэрээ байгуулж, зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих хэрэгтэй.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газрын асуудлыг шийдвэрлэх тогтолцоог дор схемээр харуулав



5.3 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулах

Аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэрийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга өргөдөл гаргасан дарааллын дагуу Бичил уурхай эрхлэгч этгээдтэй Ашигт малтмал олборлох гэрээ байгуулна. Өргөдөл гаргасан Бичил уурхай эрхлэгч этгээд нь бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт сум, дүүргийн Засаг даргатай Ашигт малтмал олборлох гэрээ байгуулсны үндсэн дээр албан ёсоор ашигт малтмал олборлох эрхтэй болно.

“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ”-г тухайн талбай дахь ашигт малтмалыг ашиглаж дуусах хүртэлх хугацаагаар байгуулна. Нөхөн сэргээлт хийгээгүй буюу ашигт малтмал олборлох гэрээний үүргээ биелүүлээгүй бичил уурхай эрхлэгч этгээдтэй байгуулсан гэрээг цуцлаж, түүнтэй дахин гэрээ байгуулахгүй.

Гэрээ байгуулсан Бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхэд шаардагдах хөрөнгийг төвлөрүүлэх нөхөн сэргээлтийн дундын сан байгуулж, нөхөн сэргээлтийн ажилд зарцуулна.



Гэрээ байгуулсан Бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан талбайг буцааж хүлээлгэн өгөхдөө Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэж өгнө.

Бичил уурхай эрхлэгч этгээд нь тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Засаг даргатай зөвшилцөж, гурвалсан гэрээ байгуулсаны үндсэн дээр уурхайн эдэлбэр газар дээр ашигт малтмал олборлож болно.

Бичил уурхай эрхлэгч этгээд Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу Нөхөрлөл, Хоршоо, Бүртгэгдээгүй нөхөрлөл байгуулж бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулах, эсвэл ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Засаг даргатай зөвшилцөж, гурвалсан гэрээ байгуулсаны үндсэн дээр олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бичил уурхайчдын үйл ажиллагааг албажсан бичил уурхайн үйл ажиллагаа гэж үзнэ.

6 БИЧИЛ УУРХАЙЧДААД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Бичил уурхай нь хариуцлагатай бичил уурхайн дараах шаардлагуудыг хангаж ажиллана.

1. Албан татвар төлөх
2. Хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийн шаардлагыг хангаж ажиллах
3. Байгаль орчны шаардлагыг хангаж ажиллах
4. Олборлосон ашигт малтмалаа холбогдох хууль тогтоомжийн дагуу борлуулах
5. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайд гурвалсан гэрээгээр олборлосон тохиолдолд ашигт малтмалаа тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр дээр бүртгүүлэх



6.1 Бичил уурхай эрхлэгч ямар татвар, төлбөр төлөх вэ?

Бичил уурхай эрхлэгч этгээд нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу татвар төлнө. Дээрх хуульд зааснаар албан татвар төлөгч албан татвар ногдуулах орлогоо энэ хуулийн дагуу өөрөө үнэн зөв тодорхойлно.

Албан татвар төлөгчийн орлого, төлсөн татварыг татварын бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэн харьяа татварын албаар баталгаажуулах бөгөөд татварын жилийн эцэст уг албатай татварын тооцоо хийнэ.

Бичил уурхай эрхлэгч этгээд нь олборлосон алтаа Монгол банкинд худалдан борлуулбал Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 2.5 хувь, хэрэв экспортонд гаргасан тохиолдолд 5 хувь дээрээс нь нэмээд алтны үнийн өсөлтийн хувийг дараах аргаар тооцож төлнө. Иймд олборлосон алтаа экспортонд гаргавал алтны тухайн үеийн үнээс хамаараад 5-10 хувийн татварыг төлнө.

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Зах зээлийн үнийн түвшин /америк доллараар/	Хувь
1	Алт	унци	0-900	0.00
			900-1000	1.00
			1000-1100	2.00
			1100-1200	3.00
			1200-1300	4.00
			1300-аас дээш	5.00

Хэрэв нүүрс олборлосон бол борлуулсан бүтээгдхүүний үнийн дүнгийн 2.5 хувиар бодож, харин жонш олборлосон бол борлуулсан бүтээгдхүүний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцүү хэмжээний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлнө.

6.2 ХАБЭА-н шаардлагуудыг хангаж ажиллах

Нэгэнт бичил уурхайн бүртгэгдээгүй нөхөрлөл, нөхөрлөл, хоршоогоо хууль журмын дагуу байгуулж, олборлох газраа албан ёсоор шийдвэрлүүлж, гэрээгээ байгуулсан тохиолдолд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм журмыг биелүүлж, дагаж мөрдөх шаардалагатай. Бичил уурхайчид Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх ба үүнд тусгасан дараах нийтлэг шаардлагыг нэн тэргүүнд биелүүлж ажиллана.

6.2.1 Бичил уурхай эрхлэгч этгээд нь бичил уурхайчдын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг хариуцан ажиллана.

- Шинээр ажилд орсон бичил уурхайчдад бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг танилцуулж, аюулгүй ажиллагааны шаардлага, үүрэг, хариуцлагыг тайлбарлан таниулж, ажлын байрны урьдчилсан, анхан шатны болон давтан зааварчилгаа өгнө.



- Бичил уурхайчдад ажлын байрны урьдчилсан, анхан шатны зааварчилгаа өгсний дараа ажлыг эхлүүлнэ.
- Улиралд нэгээс доошгүй удаа ажлын байрны давтан зааварчилгаа өгнө.
- Ажлын байрны урьдчилсан, анхан шатны болон давтан зааварчилгаа авсан бичил уурхайчныг журналд бүртгэж, гарын үсэг зуруулна.
- Ажил эхлэхийн өмнө бичил уурхайчдын эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй ажиллахад шаардлагатай ажлын тусгай хувцас (малгай, бээлий гэх мэт), нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зөв өмссөн эсэх, ажил гүйцэтгэхэд шаардагдах багаж хэрэгсэл аюулгүй ажиллагааны шаардлага хангасан эсэхийг шалгана.
- Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгасны дараа ажлыг үргэлжлүүлнэ.
- Өвчтэй буюу эрүүл мэндийн байдлаар ажиллах чадваргүй байгаа бичил уурхайчныг тухайн өдөр ажилд гаргахыг хориглоно.
- Бичил уурхайчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэгээс доошгүй удаа хамруулна.
- Ослын үед анхан шатны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, хэрэгслийг бэлэн байлгана.

- Бичил уурхайд осол гарсан тохиолдолд “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу ослыг судлан бүртгэж, сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.
- Тухайн жилд гарсан ослын мэдээллийг дараа жилийн нэгдүгээр сард багтаан сум, дүүргийн Засаг дарга болон холбогдох байгууллагад хүргүүлнэ.
- Бичил уурхайд гарсан ослын шалтгааныг судалж цаашид ийм төрлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Олборлолт явуулсан талбайд хүн, мал унаж гэмтэхээс хамгаалсан хаалт тавьж, тэмдэг тэмдэглэгээ байршуулна.
- Бичил уурхайн талбайд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ус зайлуулах суваг, шуудуу гаргасан байна.
- Бичил уурхайн талбайд аюулгүй ажиллагааны анхааруулах самбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулна.

6.2.2 Бичил уурхайчдын хүлээх үүрэг

- Бичил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг судалж, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу ажиллана.
- Ажил эхлэхийн өмнө ажлын байр, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг шалгаж зөрчил илэрвэл энэ тухай ахлагчид мэдэгдэж, түүнийг арилгах арга хэмжээ авна.



- Шаардлагатай ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг иж бүрэн, зөв хэрэглэнэ.
- Осол гарах, амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, бусад бичил уурхайчдад яаралтай мэдэгдэж, аюулын бүсийг орхино.
- Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан байна.
- Тоног төхөөрөмжийн ажлын бүс, догол, мөрөгцгийн доор, тээврийн хэрэгслийн зам дээр амарч, унтахыг хориглоно.

6.2.3 Эрүүл ахуй

Бичил уурхайн тоосжилт, хорт хий, бодисын нөлөөнөөс хамгаалах

Тухайн хийж байгаа ажлын онцлогтой уялдуулан бичил уурхайчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор тоосжилттой нөхцөлд ам, хамрын хаалт, хушуувч зэрэг хамгаалалтын хэрэгслийг хүн бүр хэрэглэх, шаардлагатай тохиолдолд зохиомол агааржуулалт хийнэ.

Шуугиан, доргионы хортой нөлөөнөөс хамгаалах

Бичил уурхайн ажлын бүсийн шуугианы ерөнхий түвшин 85 дБА-аас ихгүй байх ёстой бөгөөд зөвшөөрөгдөх хэмжээнээс их шуугианд сонсголын эрхтэн хамгаалах чихний бөглөө, чихэвч хэрэглэнэ.



Бичил уурхайд чулуулгийг цохиж буулгах, бутлах, хийн алх, өрөм ашиглах үед зөөллөгч жийргэвчтэй бээлий, хамгаалалтын нүдний шил, доргион тусгаарлагч, зөөлөвчтэй гутал өмсөнө.

Бичил уурхайчдын амьдрах суурьшлын талбай, хог хаягдлын менежмент

Бичил уурхайчид олборлолтын талбайн гадна орон нутгийн засаг захиргаанаас тогтоож өгсөн суурьшлын талбайд амьдарч орон нутгийн засаг захиргаанаас тогтоосон цэгт ариун цэврийн шаардлага хангасан хог хаягдлын цэг болон бие засах газар барьж байгуулна.



6.3 Байгаль орчны шаардлагуудыг хангаж ажиллах

Бичил уурхай эрхлэгч этгээд нь Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд заасны дагуу олборлолт явуулсан талбайд нөхөн сэргээлт хийх ажлын төлөвлөгөө, төсөв, зардлын эх үүсвэрийн баталгааг гаргаж сум/дүүргийн Засаг даргатай байгуулах гэрээндээ тусгаж ажиллана. Бичил уурхай эрхлэгч этгээд нь олборлолтын талбайгаа буцааж хүлээлгэн өгөхийн өмнө тухайн талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг “Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал”-ын дагуу хийж, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан, сум, дүүргийн Засаг даргын томилсон комисст актаар хүлээлгэн өгнө.

Бичил уурхай эрхлэгч этгээд болон нутгийн захиргааны байгууллага нь нөхөн сэргээлтийн дундын сангийн мөнгөн

хөрөнгийг зөвхөн бичил уурхайгаар олборлолт явуулсан талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зориулалтаар хамтран захиран зарцуулна.



6.4 Олборлосон ашигт малтмалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу борлуулах

Албан ёсоор бичил уурхай эрхэлж буй этгээд олборлосон ашигт малтмалаа Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжуудад заасны дагуу худалдан борлуулах үүрэгтэй байдаг.

Алт борлуулалтын албан сүлжээ: Ашигт малтмалын тухай хуулийн 46.3-т Монгол банк үнэт металл, эрдэнийн чулууг худалдан авах ёстой гэдгийг хуульчилсан байдаг бол тус хуулийн 46.4-т ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон үнэт металл, эрдэнийн чулууг Монголбанкаар дамжуулан экспортод гаргаж болно гэж заажээ. Эндээс дүгнэхэд хуулийн дагуу алтыг Монгол банкинд тушаах ёстой эсвэл экспортод гаргаж болдог байна. Энэ хоёр тохиолдлын алинаар нь ч алт борлуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлдөг бөгөөд эдгээрийг алт борлуулах албан сүлжээ гэж нэрлэнэ. Үүнээс өөр хэлбэрээр алтыг худалдан борлуулбал өнөөгийн хууль тогтоомжоор бол албан бус худалдаа хийж байна гэж үзэх юм.

Манай өнөөгийн нөхцөлд бичил уурхайчид орон нутгийн алтны худалдаачдад алтаа тушаадаг практик түлхүү байгаа нь олборлосон алтаа хуулийн дагуу бус албан бусаар борлуулж байгаа хэлбэр юм.

Иймд албажсан бичил уурхай эрхлэгчид албан шугамаар алтаа борлуулж, Монгол улсынхаа макро эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж байх үүрэгтэйгээ ухамсарлах ёстой.

Ашигт малтмалын тухай хуулийн 46.1-т орборлосон бүх төрлийн үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар тогтоолгож, тоо хэмжээг бүртгүүлнэ гэж заасан байдаг. Иймд албан шугамаар алт борлуулахад заавал Үнэт металлын сорьцын хяналтын газарт хандаж алтныхаа сорьцыг тогтоолгосон байх ёстой ажээ.

Мөн ашигт малтмалын тухай хуулийн 46.5-д 400 граммаас дээш жинтэй эсхүл түүнээс хөнгөн боловч онцгой чамин дүрс хэлбэртэй байгалийн төрц алт, түүнчлэн ховор өнгө, дүрстэй эрдэнийн чулуу олборлосон бол тэдгээрийг Монголбанкны Эрдэнэсийн санд урамшуулалтай үнээр худалдах үүргийг оногдуулсан байдаг.

Нүүрсний борлуулалтын албан сүлжээ: Нүүрс нь эрдэнийн чулуу биш бөгөөд ахуйн хэрэгцээнд өргөн хэрэглэгддэг бүтээгдэхүүн юм. Иймд нүүрсийг дотооддоо борлуулахдаа эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2.5 хувьтай тэнцүү хэмжээгээр нүүрсний нөөц ашигласны төлбөр төлөх ёстойг Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.1-д тодорхой заасан байдаг. Иймд



та борлуулсан нүүрснээсээ нүүрсний нөөц ашигласны төлбөр төлөх ёстой бөгөөд хэрэв төлж байгаа бол албан худалдаа хийж байна гэж ойлгож болох нь байна. Та нэгэнт нүүрсний албажсан бичил уурхайчин болж байгаа бол энэ төлбөрийг төлж, Монгол улсын макро эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүрэг хүлээнэ.

Жоншны борлуулалтын албан сүлжээ: Өнөөгийн практикаар бичил уурхайчид олборлосон жоншоо дотоодын жонш боловсруулах үйлдвэрүүдэд болон жонш экспортод гаргах эрх бүхий хуулийн этгээдүүдэд урьдчилан байгуулсан гэрээний үндсэн дээр борлуулдаг. Бичил уурхайчид ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч биш тул олборлосон жоншоо өөрсдөө экспортлох эрх байхгүй. Жоншийг борлуулахдаа жоншны нөөц ашигласны төлбөрийг заавал төлнө. Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.2-т алт болон нүүрснээс бусад төрлийн байгалийн нөөц ашигласны төлбөр нь уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдхүүний борлуулалтын үнэлгээний 5 хувьтай тэнцүү байна гэж заажээ. Бүтээгдхүүний үнэлгээг тогтоох аргачлалуудыг Ашигт малтмалын тухай хуулийн 47.2.1; 47.2.2; 47.2.3 дугаар заалтуудад тодорхой заасан байдаг.

Дээрхээс дүгнэхэд бичил уурхай эрхлэгчид хуульд заасны дагуу байгалийн нөөц ашигласны төлбөр төлөх замаар олборлосон байгалийн баялгаа худалдан борлуулж байвал албан сүлжээгээр худалдаа хийж байна гэж үзэж болох юм.

7

БИЧИЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОРИГЛОХ ЗҮЙЛС

- a) олборлолтын талбайд 18 нас хүрээгүй хүнийг иргэнийг байлгах, ажиллуулах;
- b) хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм зөрчих;
- c) гэрээгээр олгосон газраас бусад газарт ашигт малтмал агуулсан шороо, хүдрийг угааж баяжуулах;
- d) албан татвар төлөхөөс зайлсхийх;
- e) гишүүн бус этгээдийг оролцуулах;
- f) химийн хорт болон аюултай бодис ашиглах;
- g) тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах;
- h) гэрээгээр олгосон талбайг зориулалт бусаар ашиглах, бусдад шилжүүлэх, барьцаалах, худалдах;
- i) байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлэх;



- j) нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгч этгээд нь ашигт малтмал олборлохдоо 3500 см^3 хүртэлх багтаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий 2-оос илүүгүй механизмыг ашиглах;
- k) гурвалсан гэрээг байгуулахгүйгээр ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбайд зэрэгцэн үйл ажиллагаа явуулах.

ХОЛБОО БАРИХ:

Монгол Улс, Улаанбаатар хот
Скай Плаза Бизнес төв
Элчингийн гудамж
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

 +976 11 328848

 +976 11 322415

 info@sam.mn

 www.sam.mn

 ASM Mongolia

 ASM_Mongolia

© Энэхүү гарын авлагыг худалдахыг хориглоно.